



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1/112

Хөхбүрд

Г Техник, биологийн нөхөн сэргээлтийг
хийлгэх, хүлээн авах тухай

Монгол Улсны Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.18 заалтын "д" хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 4 дүгээр зүйлийн 4.1.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 7/6356 дугаартай дүгнэлтийн хүрээнд "Алтан усны Ундрага" ЗБН сүүлийн 3 жилийн турш үйл ажиллагаа явуулсан бөгөөд нөхөн сэргээлт хийсэн талбайгаа хүлээлгэн өгөөгүй 2018 оноос хойш бичил уурхайн зориулалтаар олгогдсон дүгнэлт бүхий талбайд ажилласан нийт газрыг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор нөхөн сэргээлтийг бүрэн хийж хүлээлгэн өгөхийг "Алтан усны ундрага" ЗБН-ийн ахлагч Н.Янжиндуламд, "Баянтээгийн өндөр толгой" ЗБН-н ахлагч П. Амарсайхан нарт үүрэг болгосугай.

2. Мандалхайрхан 1 дүгээр багийн нутагт ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй "Андын тэмүүлэл" ХХК, "Монголболгаргео" ХХК-ниудын хаалтын төлөвлөгөө хэрэгжиж байгаатай холбоотой хиймэл нуур, бууны суурь, овоолго шороо болон бусад үлдсэн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг 2023 оны 08 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгэж аймаг, сумын хамтарсан ажлын хэсэгт хүлээлгэн өгөхийг компаниудийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон нөхөрлөлийн техникийн нөхөн сэргээлтийг 2023 оны 09 дүгээр сарын 07-ний дотор хүлээн авах, нөхөн сэргээлтийг заасан хугацаанд хийж хэрэгжүүлээгүй, хүлээлгэн өгөөгүй иргэн, аж ахуй нэгж, нөхөрлөлийн хохирлын үнэлгээ тооцуулах, нөхөн төлбөрийн орон нутгийн нөхөн сэргээлтийн санд байршуулан гүйцэтгүүлэх арга хэмжээг зохион байгуулах, шүүхийн байгууллагад шилжүүлэн дараагийн үйл ажиллагааг явуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах зэрэг хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.ХАТАНБААТАР

642301055

Сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны
өдрийн 1 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



Ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын Орлогч)

Т. Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С. Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

П. Мөнхтоогоо (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Н.Ганзориг (Газрын харилцаа барилга хот байгуулалтын албаны мэргэжилтэн)

ЗДТГ-ийн хууль эрх зүйн мэргэжилтэн

М. Ганбаатар (Байгаль хамгаалагч)

Б. Энхмөнх (Жолооч)

Багуудын иргэдийн төлөөлөл

----- оОо -----